

Япон хэлний өдөрлөг

ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулиас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг арга хэмжээний нэг бол “Япон хэлний өдөрлөг” юм. Тус арга хэмжээг 2008 оноос зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2008-2017 оны хооронд жил бүрийн намар, ГХС-ийн зохион байгуулдаг “Япон хэлээр хэн уран илтгэх вэ” уран илтгэлийн тэмцээнтэй хамтатган явуулж, 2017 оноос хойш жил бүрийн хаврын улиралд мэргэжлийн ангийн болон япон хэлийг сонгон суралцаж байгаа оюутнууд, япон хэлний “Хитонэн” клубийн гишүүд хамтран зохион байгуулах болсон. Мөн ГХС-аас гадна МХТС, БуХС, МТС зэрэг салбар сургууль дээр зохион байгуулж байна. Өдөрлөгөөр дамжуулан оюутан залууст япон хэл, соёлыг таниулах, суралцах идэвх сонирхлыг эрчимжүүлэх, оюутнуудын харилцааг хөгжүүлэх, оюутнуудын бие даах идэвхийг өргөжүүлэх, мөн мэргэжил сурталчлах зорилгоор зохион байгуулдаг.

Өдөрлөгт япон хэлний ангийн оюутнууд болон ШУТИС-ийн Хитонэн клубийн гишүүд дуу, бүжгээр мэндчилгээ дэвшүүлдэг уламжлал тогтсон. Өдөрлөг нь уран бичлэг, манга, юката өмсгөл, цаасан нугалбар, косплэй, тоглоом гэсэн соёлын булангаас бүрдсэн. Мөн дээрх булангуудыг үзэж сонирхсон оюутан залуусын дунд азын сугалааг зохион байгуулдаг.

2017.11 сард Б.Ундармаа багш мэргэжлийн анги болон япон хэл сонгон суралцаж буй оюутнуудын хамт ГХИ, БАС, МХТС дээр тус тус зохион байгуулсан.

2018. 04 сард О.Халиун, С.Оюундэлгэр багш нар оюутнуудын хамт ГХИ, МТС, БАС, БуХС дээр амжилттай зохион байгуулсан.

2019. 04 сард О.Халиун багш оюутнуудын хамт ГХС, БуХС, МТС дээр тус тус зохион байгуулж, олон оюутнуудыг хамруулсан.

2021.04 сард Э.Сайнбилэг багш оюутнуудын хамт ГХС, МТС, МХТС дээр тус тус зохион байгуулж, олон оюутнуудыг хамруулсан.

2022.04 сард Б.Эрдэнэчулуун, С.Оюундэлгэр багш нар оюутнуудын хамт ГХС, МТС, МХТС дээр амжилттай зохион байгуулсан.

2023.10 сард Б.Ундармаа, Т.Солонго багш нар мэргэжлийн ангийн оюутнуудын хамт АСС-ын нэгдсэн арга хэмжээ болгон зохион байгуулж оролцсон.



